

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан.

Аудитын код: СНАГ-2024/3/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2024 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: **Ц.Наранчимэг**  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
**Аудитын менежер: Ч.Болд**  
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn  
**Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ**  
Утас: 261628 Цахим хаяг: Bat-Erdenes@audit.gov.mn  
**Аудитор: П.Ариунзаяа**  
Утас: 261628 Цахим хаяг: Ariunzayap@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА А.НАРАНТУЯА  
ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/837  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Мал эмнэлгийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 3,818.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байгаа нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Их хурлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр баталсан “Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.12-д зааснаар Мал эмнэлгийн алба нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага болгон хуульчилсан байна.

## Аудитын гол асуудал

Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 21 аймаг, нийслэлийн 334 сум, дүүргийн 36.3 сая толгой мал сүргийг нийт 4 төрлийн гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулсан байна.

Тайлант онд гоц халдварт өвчний 210 голомт бүртгэгдэж, 27,682 толгой мал өвчилсөн нь суурь түвшнээс голомт 62.0 хувиар, өвчилсөн малын тоо 92.0 хувиар тус тус буурсан байна.

## Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 15 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 85.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,866,528.4</b>	<b>18,575,048.8</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,800.0	8,470.0
33	АВЛАГА	89,428.0	415,351.0
34	УРЬДЧИЛГАА	6,106.1	641.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8,767,194.2	18,150,586.4
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>27,700,004.6</b>	<b>32,261,037.8</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,700,004.6	32,261,037.8
39200	Биет хөрөнгө	24,983,546.1	29,167,274.0
39300	Биет бус хөрөнгө	2,716,458.4	3,093,763.7
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>36,566,533.0</b>	<b>50,836,086.5</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>969,888.0</b>	<b>320,159.4</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	969,888.0	320,159.4
41300	Өглөг	969,888.0	320,159.4
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>35,596,645.0</b>	<b>50,515,927.2</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	35,596,645.0	50,515,927.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	9,653,568.5	9,675,893.6
51200	Хуримтлагдсан үр дүн	21,831,479.5	36,728,756.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,111,596.9	4,111,277.6
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>36,566,533.0</b>	<b>50,836,086.5</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>82,600,854.9</b>	<b>114,589,528.3</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,125,592.3	17,812,831.6
120	Нийтлэг татварын бус орлого	24,125,592.3	17,812,831.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	58,475,262.6	96,776,696.7
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>84,263,071.6</b>	<b>99,672,626.7</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,263,071.6	99,672,626.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,356,412.5	96,001,374.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,926,587.8	22,219,095.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,685,045.9	2,885,859.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	716,336.8	939,082.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,771,619.1	1,273,173.6
2105	Нормативт зардал	35,109,154.4	27,803,986.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	435,210.2	532,034.5
2107	Томилолт, зочны зардал	394,758.9	671,287.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,096,632.4	34,424,066.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,221,067.1	5,252,789.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,906,659.1	3,671,252.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-1,662,216.8</b>	<b>14,916,901.5</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>344,572.8</b>	<b>130,757.8</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-2,006,789.5</b>	<b>14,786,143.7</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>59,611,197.80</b>	<b>97,982,280.10</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,056,296.30	1,304,684.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,056,296.30	1,304,684.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	58,554,901.60	96,677,595.60
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>59,294,270.60</b>	<b>97,486,042.60</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,294,270.60	97,486,042.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,377,284.10	93,623,958.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,944,448.50	22,244,777.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,683,291.90	2,889,214.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	714,853.40	976,088.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,021,734.80	1,057,441.00
2105	Нормативт зардал	16,087,868.30	28,149,200.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	631,224.50	889,587.30
2107	Томилолт, зочны зардал	392,322.40	673,525.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,766,877.50	36,545,009.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,662.80	199,114.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,916,986.40	3,862,084.50
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>316,927.30</b>	<b>496,237.50</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>313,127.40</b>	<b>491,567.50</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	313,127.40	491,567.50
2200	Дотоод эх үүсвэрээр	313,127.40	491,567.50
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-313,127.40</b>	<b>-491,567.50</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>3,799.90</b>	<b>4,670.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.1	3,800.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,800.00	8,470.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>37,354,333.4</b>	<b>0.0</b>	<b>37,354,333.4</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-55,458.3	0.0	-55,458.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,298,875.1	0.0	37,298,875.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-18.6	0.0	-18.6
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	304,578.0	0.0	304,578.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-2,006,789.5	0.0	-2,006,789.5
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,596,645.0	0.0	35,596,645.0
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>35,596,645.0</b>	<b>0.0</b>	<b>35,596,645.0</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	111,132.8	0.0	111,132.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,707,777.7	0.0	35,707,777.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-319.4	0.0	-319.4
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	22,325.1	0.0	22,325.1
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	14,786,143.7	0.0	14,786,143.7
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>50,515,927.2</b>	<b>0.0</b>	<b>50,515,927.2</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>87,665,568,300.0</b>	<b>85,004,077,391.1</b>	<b>2,661,490,908.9</b>	<b>97.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>87,665,568,300.0</b>	<b>85,004,077,391.1</b>	<b>2,661,490,908.9</b>	<b>97.0</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>86,710,716,200.0</b>	<b>84,153,860,889.4</b>	<b>2,556,855,310.6</b>	<b>97.1</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>23,874,415,100.0</b>	<b>21,948,778,613.5</b>	<b>1,925,636,486.5</b>	<b>91.9</b>
Үндсэн цалин	14,195,113,300.0	13,831,500,382.7	363,612,917.3	97.4
Нэмэгдэл	6,730,029,600.0	5,264,426,510.4	1,465,603,089.6	78.2
Унаа хоолны хөнгөлөлт	1,327,482,500.0	1,380,946,364.0	(53,463,864.0)	104.0
Урамшуулал	1,614,789,700.0	1,471,905,356.4	142,884,343.6	91.2
Гэрээт ажлын хөлс	7,000,000.0	-	7,000,000.0	-
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>3,046,950,800.0</b>	<b>2,860,449,929.7</b>	<b>186,500,870.3</b>	<b>93.9</b>
Тэтгэврийн даатгал	2,083,070,200.0	1,950,407,490.3	132,662,709.7	93.6
Тэтгэмжийн даатгал	240,204,400.0	227,719,027.9	12,485,372.1	94.8
ҮОМШӨ-ний даатгал	196,596,400.0	210,280,210.6	(13,683,810.6)	107.0
Ажилгүйдлийн даатгал	48,028,500.0	42,871,559.5	5,156,940.6	89.3
Эрүүл мэндийн даатгал	479,051,300.0	429,171,641.5	49,879,658.5	89.6
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,035,485,400.0</b>	<b>976,087,962.8</b>	<b>59,397,437.2</b>	<b>94.3</b>
Гэрэл, цахилгаан	324,836,300.0	287,110,516.0	37,725,784.0	88.4
Түлш, халаалт	525,487,400.0	510,676,066.0	14,811,334.0	97.2
Цэвэр, бохир ус	50,644,600.0	44,707,639.1	5,936,960.9	88.3
Байрны түрээс	134,517,100.0	133,593,741.8	923,358.3	99.3
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>765,345,700.0</b>	<b>754,508,740.6</b>	<b>10,836,959.4</b>	<b>98.6</b>
Бичиг хэрэг	137,648,100.0	138,098,831.9	(450,731.9)	100.3
Тээвэр, шатахуун	361,082,900.0	360,209,390.0	873,510.0	99.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90,490,900.0	81,616,574.1	8,874,325.9	90.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,590,600.0	4,116,700.0	473,900.0	89.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	171,533,200.0	170,467,244.6	1,065,955.4	99.4
<b>Нормативт зардал</b>	<b>25,441,632,800.0</b>	<b>25,429,477,424.8</b>	<b>12,155,375.2</b>	<b>100.0</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,428,139,700.0	25,417,750,024.8	10,389,675.2	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,493,100.0	11,727,400.0	1,765,700.0	86.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,360,313,800.0</b>	<b>1,111,693,431.0</b>	<b>248,620,369.0</b>	<b>81.7</b>
Багаж, техник, хэрэгсэл	789,050,200.0	559,484,230.0	229,565,970.0	70.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	48,261,500.0	47,720,600.0	540,900.0	98.9
Урсгал засвар	523,002,100.0	504,488,601.0	18,513,499.0	96.5
<b>Томилот, зочны зардал</b>	<b>514,820,300.0</b>	<b>447,509,315.0</b>	<b>67,310,985.0</b>	<b>86.9</b>
Дотоод албан томилот	514,820,300.0	447,509,315.0	67,310,985.0	86.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>30,521,840,100.0</b>	<b>30,477,980,552.0</b>	<b>43,859,548.0</b>	<b>99.9</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	30,254,572,400.0	30,221,460,082.5	33,112,317.5	99.9

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

үйлчилгээний төлбөр хураамж				
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	33,663,300.0	32,956,000.0	707,300.0	97.9
Даатгалын үйлчилгээ	25,451,700.0	23,364,399.0	2,087,301.0	91.8
Тээврийн хэрэгслийн татвар	14,201,000.0	11,199,767.5	3,001,232.5	78.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,637,600.0	2,826,510.0	811,090.0	77.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	174,090,400.0	171,246,200.0	2,844,200.0	98.4
Газрын төлбөр	16,223,700.0	14,927,593.0	1,296,107.0	92.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>149,912,200.0</b>	<b>147,374,920.0</b>	<b>2,537,280.0</b>	<b>98.3</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	140,238,400.0	139,088,920.0	1,149,480.0	99.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,673,800.0	8,286,000.0	1,387,800.0	85.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>954,852,100.0</b>	<b>850,216,501.7</b>	<b>104,635,598.3</b>	<b>89.0</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>954,852,100.0</b>	<b>850,216,501.7</b>	<b>104,635,598.3</b>	<b>89.0</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,350,000.0	4,721,500.0	4,628,500.0	50.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	846,012,500.0	753,467,782.7	92,544,717.3	89.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	99,489,600.0	92,027,219.0	7,462,381.0	92.5
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>87,665,568,300.0</b>	<b>85,004,247,391.1</b>	<b>2,661,320,908.9</b>	<b>97.0</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>86,526,973,900.0</b>	<b>83,710,612,960.1</b>	<b>2,816,360,939.9</b>	<b>96.7</b>
Улсын төсвөөс санхүүжих	86,526,973,900.0	83,710,612,960.1	2,816,360,939.9	96.7
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,138,594,400.0</b>	<b>1,293,634,431.0</b>	<b>(155,040,031.0)</b>	<b>113.6</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,138,594,400.0	1,292,375,431.0	(153,781,031.0)	113.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,259,000.0	(1,259,000.0)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	170,000.0	(170,000.0)	
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>2,638.0</b>	<b>2,382.0</b>	<b>256.0</b>	<b>90.3</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>24.0</b>	<b>24.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	24.0	24.0	-	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>1,307.0</b>	<b>1,179.0</b>	<b>128.0</b>	<b>90.2</b>
Удирдах ажилтан	25.0	24.0	1.0	96.0
Гүйцэтгэх ажилтан	1,212.0	1,071.0	141.0	88.4
Үйлчлэх ажилтан	70.0	84.0	(14.0)	120.0
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>1,307</b>	<b>1,179</b>	<b>128</b>	<b>90.2</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	958	837	121	87.4
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	6	6	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	343	336	7	98.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>35,322,362,159.29</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>35,294,962,179.29</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>34,863,775,082.87</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>295,998,934.16</b>
Үндсэн цалин		14,469,380.06
Нэмэгдэл		168,270,652.89
Урамшуулал		53,555,250.00
Гэрээт ажлын хөлс		59,703,651.21
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>28,764,514.80</b>
Тэтгэврийн даатгал		23,579,622.05
Тэтгэмжийн даатгал		1,279,274.00
ҮОМШӨ-ний даатгал		1,534,625.30
Ажилгүйдлийн даатгал		252,017.38
Эрүүл мэндийн даатгал		2,118,976.07
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>305,880,736.01</b>
Бичиг хэрэг		20,084,018.00
Тээвэр, шатахуун		266,926,344.01
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		100,000.00
Ном, хэвлэл		11,903,900.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		6,866,474.00
<b>Нормативд зардал</b>		<b>2,771,024,134.00</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		2,755,020,934.00
Хоол, хүнс		8,788,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		7,215,200.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>92,631,338.00</b>
Багаж, техник, хэрэгсэл		47,602,400.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		25,674,400.00
Урсгал засвар		19,354,538.00
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>298,056,184.00</b>
Дотоод албан томилолт		298,056,184.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>31,019,679,341.90</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		31,019,679,341.90
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>51,739,900.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		40,719,900.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		11,020,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>431,187,096.42</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>169,093,807.00</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		169,093,807.00
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>262,093,289.42</b>
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		262,093,289.42
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>27,399,980.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>27,399,980.00</b>
Бусад хөрөнгө		27,399,980.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>35,322,362,159.29</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>35,322,362,159.29</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		212,824,797.97
ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,018,887,428.32
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		24,929,510,395.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		161,139,538.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 996.7 сая төгрөгийн 19 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 386.1 сая төгрөгийн 16 алдааг залруулж, 610.6 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар нийт 3,818.4 сая төгрөгийн 48 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 18.9 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 262.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлж, 3,537.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 29 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрсэн 3,818.4 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 846.1 сая төгрөгөөс өндөр тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

#### Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 25 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 20 байгууллагад бие даасан дүгнэлт гаргаж, 5 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна. Харьяа 19 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 1,502.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 332.8 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 18.9 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 76.4 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,074.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 27 зөвлөмжийг өгсөн байна.

#### Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 53.3 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

- Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 3 албан хаагчид ажилгүй байсан хугацааны цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 34.7 сая төгрөгийг байгууллагын төсвөөс төлснийг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй, санхүүгийн тайланд авлага үүсгээгүйг;
- Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд Төрийн аудитын байгууллагад аудит хийлгүүлэхээр хүргүүлсэн санхүүгийн тайланд байгууллагад төлөх 7.1 сая төгрөгийн өр төлбөрийг дутуу тайлагнасан;
- Санхүүгийн тайланд нэмэлт санхүүжилтийн 11.6 сая төгрөгийн орлогын дансны ангилал буруу бүртгэж, тайлагнасан.

Аудитаар нийт 3,259.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 186.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 3,073.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **Албан шаардлага**

1. Худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөж зохион байгуулаагүйгээс нийт 181.4 сая төгрөгийн ажил, үйлчилгээний худалдан авалтыг 12 гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2021 оны 124 дүгээр тогтоол “харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаартай” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөөгүй, бараа, ажил, үйлчилгээний төсөв өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын зохих аргыг хэрэглээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа 5 байгууллагын туслах үйл ажиллагааны орлого төлөвлөснөөс 4.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийг үндэслэлтэй төлөвлөж хянуулаагүйгээс Төсвийн тухай хуулиар хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах, албан шаардлага өгөв.

## **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жилийн эцсийн санхүүгийн тайланд шинээр нэмэгдсэн байгууллагаас авах 5.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж, он дамжсан авлага үүсгэхгүй байх, үлдэгдлийг барагдуулах.

2. Бараа материал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын дансанд мялзан өвчний 433,800 тун, хонины цэцэг өвчний 65,600 тун, нийт 106.1 сая төгрөгийн 2022 оноос шилжин ирсэн, хугацаа дууссан вакцины үлдэгдлийг устгаж, данс бүртгэлээс хасаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2023 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/289 дугаар тушаалтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хугацаа нь дууссан, цаашид хэрэглэх боломжгүй малын эм, вакцины үлдэгдлийг устгах ажлыг холбогдох хуулийн хүрээнд зохион байгуулж, данснаас хасах.

3. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Программ хангамжийн дансанд шинээр программ нэвтрүүлсэнтэй холбоотойгоор ашиглахаа больсон 3.6 сая төгрөгийн анхны өртөгтэй 2 төрлийн программ хангамж бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ашиглахгүй байгаа программ хангамжийн ашиглалтыг сайжруулж, хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, цаашид ашиглах боломжгүй болсон программ хангамжийг актлах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх.

4. Өр төлбөр данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөрийн үлдэгдлээр тайлагнаагүй Шүлхий өвчнөөс сэргийлэх намрын нэгдсэн дархлаажуулалтын ажлын 2,373.3 сая төгрөг, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын 584.2 сая төгрөг, нийт 2,957.5 сая төгрөгийн тарилгын хөлсийг тайланд оны зардлаар хүлээн зөвшөөрч, шилжүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлант оны төлөвлөгөөт болон яаралтай дархлаажуулалтын ажлыг товлосон хугацаанд гүйцэтгүүлж, МЭҮН-үүдэд олгох үйлчилгээний хөлстэй холбоотой өр төлбөрийг санхүүгийн тайланд үнэн зөвөөр тусгаж байх.

5. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд Төрийн Аудитын байгууллагад аудит хийлгүүлэхээр хүргүүлсэн ТШЗ-ийн санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нэмэлт санхүүжилтийн тайлан, тохируулгын тайланг ирүүлээгүй, ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, тэмдэглэл, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж, толилуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 8 дугаар зүйлийн 8.1.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, ..... тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 54 дүгээр зүйлийн 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тэмдэглэл, урсгал төсвийн болон нэмэлт санхүүжилтийн тайлан, төсвийн тохируулгын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу иж бүрэн бэлтгэн, толилуулж байх.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 996.7 сая төгрөгийн 19 алдаа<sup>3</sup> илэрснээс аудитын явцад 386.1 сая төгрөгийн 16 алдааг залруулж, 610.6 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн байна.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
								Үүнээс					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Говь-Алтай амьгийн МЭГ	3	1,475.7	0	-	3	1,475.7	3	1,475.7	0	-	0	-
2	Дорнод аймгийн МЭГ	2	557,622.3	0	-	2	557,622.3	1	111,253.4	1	446,368.9	1	446,368.9
3	Дундговь аймгийн МЭГ	7	207,580.7	7	207,580.7	0	-	7	207,580.7	0	-	0	-
4	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	3	53,336.6	2	41,725.1	1	11,611.5	3	53,336.6	0	-	0	-
5	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори	1	3,557.6	1	3,557.6	0	-	0	-	1	3,557.6	1	3,557.6
6	Орхон аймгийн МЭГ	1	12,452.0	0	-	1	12,452.0	1	12,452.0	0	-	0	-
7	Хөвсгөл аймгийн МЭГ	1	-	0	-	1	-	1	-	0	-	0	-
8	Өмнөговь аймгийн МЭГ	1	160,668.1	0	-	1	160,668.1	0	-	1	160,668.1	1	160,668.1
<b>Нийт дүн</b>		<b>19</b>	<b>996,693.0</b>	<b>10</b>	<b>252,863.4</b>	<b>9</b>	<b>743,829.5</b>	<b>16</b>	<b>386,098.4</b>	<b>3</b>	<b>610,594.5</b>	<b>3</b>	<b>610,594.5</b>

<sup>3</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
		Нийт зөрчил		Үүнээс									Хариуцлага тооцуулах албан шаардлага	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн	Тоо		
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				Тоо	Албан тушаалтны тоо
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11		
1	Булган аймгийн МЭГ	2	900.0	1	900.0	0	-	1	-					
2	Говь-Алтай амйгийн МЭГ	3	1,594.8	1	870.8	1	724.0	1	-					
3	Говьсүмбэр аймгийн МЭГ	3	3,986.4	2	135.4	0	-	1	3,851.0					
4	Дархан-Уул аймгийн МЭГ	1	5,999.0	0	-	0	-	1	5,999.0					
5	Дорноговь аймгийн МЭГ	2	-	0	-	0	-	2	-					
6	Завхан аймгийн МЭГ	1	726.0	1	726.0	0	-	0	-					
7	Мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	6	29,963.4	2	3,370.0	2	26,097.8	2	495.6					
8	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	5	3,254,681.2	0	-	1	181,400.0	4	3,073,281.2					
9	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори	1	2,000.0	0	-	0	-	1	2,000.0					
10	Нийслэлийн МЭГ	2	-	0	-	0	-	2	-					
11	Орхон аймгийн МЭГ	1	276.0	0	-	0	-	1	276.0					
12	Сэлэнгэ аймгийн МЭГ	2	9,330.0	0	-	1	9,000.0	1	330.0					
13	Сүхбаатар аймгийн МЭГ	2	9,792.4	1	1,061.4	1	8,731.0	0	-					
14	Төв аймгийн МЭГ	3	4,944.9	0	-	0	-	3	4,944.9					
15	Увс аймгийн МЭГ	4	444,394.1	0	-	0	-	4	444,394.1					
16	Ховд аймгийн МЭГ	1	-	0	-	0	-	1	-					
17	Хөвсгөл аймгийн МЭГ	2	1,466.4	0	-	0	-	2	1,466.4					
18	Өвөрхангай аймгийн МЭГ	2	31,846.7	0	-	2	31,846.7	0	-					
19	Өмнөговь аймгийн МЭГ	3	11,842.0	2	11,842.0	0	-	1	-					
20	Мал эмнэлгийн ерөнхий газар ТТЗ	2	4,694.3	0	-	1	4,694.3	1	-					
<b>Нийт дүн</b>		<b>48</b>	<b>3,818,437.6</b>	<b>10</b>	<b>18,905.5</b>	<b>9</b>	<b>262,493.8</b>	<b>29</b>	<b>3,537,038.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>		

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийцлийн аудитын асуудлаар нийт 1,394.0 сая төгрөгийн 17 зөрчил илэрснээс, 877.7 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 516.3 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмж өгсөн байна.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
1	Булган аймгийн МЭГ	1	-	-	-	-	-	1	-
2	Дорнод аймгийн МЭГ	1	457,120.1	-	-	1	457,120.1	-	-
3	Дорноговь аймгийн МЭГ	1	52,160.5	-	-	-	-	1	52,160.5
4	Дундговь аймгийн МЭГ	1	-	-	-	1	-	-	-
5	Мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	1	244,740.3	-	-	1	244,740.3	-	-
6	Нийслэлийн МЭГ	1	-	-	-	-	-	1	-
7	Төв аймгийн МЭГ	1	-	-	-	-	-	1	-
8	Мал эмнэлгийн ерөнхий газар ТТЗ	1	-	-	-	-	-	1	-
	<b>Дүн</b>	<b>8</b>	<b>754,020.9</b>	-	-	<b>3</b>	<b>701,860.4</b>	<b>5</b>	<b>52,160.5</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
1	Булган аймгийн МЭГ	1	-	-	-	-	-	1	-
2	Дорноговь аймгийн МЭГ	1	-	-	-	-	-	1	-
3	Мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори	2	156,895.8	-	-	2	156,895.8	-	-
4	Мал эмнэлгийн ерөнхий газар ТШЗ	2	18,974.0	-	-	1	18,974.0	1	-
5	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори	1	37,361.4	-	-	-	-	1	37,361.4
6	Төв аймгийн МЭГ	1	426,744.0	-	-	-	-	1	426,744.0
7	Мал эмнэлгийн ерөнхий газар ТТЗ	1	-	-	-	-	-	1	-
	<b>Дүн</b>	<b>9</b>	<b>639,975.2</b>	-	-	<b>3</b>	<b>175,869.8</b>	<b>6</b>	<b>464,105.4</b>
	<b>Нийт дүн</b>	<b>17</b>	<b>1,393,996.1</b>	-	-	<b>6</b>	<b>877,730.2</b>	<b>11</b>	<b>516,265.9</b>